



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/254

Улиастай

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Б.Чадраабал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ж.Лхагвасүрэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Бямбасүрэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Б.Хулан

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн  
дарга:


Б.Амарзаяа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан этгээдийн материалын бүрдлийг шалгаж, дүгнэлт гарган зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд хүргүүлж байхыг ажлын хэсэг (Б.Чадраабал)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Т.Рэнчинванжил)-т даалгасугай.

ДАРГА  Т.РЭНЧИНВАНЖИЛ



8109010897  
Захирамж-2024